

БНХАУ ДАХЬ УЛС ТӨРИЙН СИСТЕМИЙН ШИНЭТГЭЛ

Ч. ЭРДЭНЭБАЯР

1978 онд хуралдсан ХКН-ын ТХ-ны III бүгд хурал «дөрвөн шинэчлэлт» -ийн бодлогыг гүнзгийрүүлэн ард түмнийхээ материаллаг аж байдлыг сайжруулах чиг шугамыг тунхаглан зарласан юм. ХКН энэхүү чиг шугамыг хэрэгжүүлэх явдлаа социалист эдийн засгийн хуулиас урган гарч буй зүй ёсны шаардлага хэмээн үзэж, дотоод бодлогодоо улс төрийн ардчиллыг хөгжүүлэх, эдийн засгийн шинэтгэлийг хэрэгжүүлэх хоёр чухал зорилтыг дэвшүүлэн¹ тавьжээ.

Хятадад эдийн засгийн системийн шинэтгэл хийх ажлыг 1978 оноос Хөдөө тосгодод анх эхэлсэн бөгөөд 1984 онд хуралдсан ХКН-ын ТХ-ны III бүгд хурлаар уг ажил хот суурин газруудад шилжиж эдүгээ эдийн засгийн бүхий л салаа салбарыг хамарсан эрчимтэй шинэтгэл болон хувирч байна. Мөнхүү шинэтгэлийн үр нөлөөгөөр Хятадын нийгэм эдийн засгийн амьдралд;

— Натурал, хагас натурал аж ахуй нь социалист төлөвлөгөөт таваарын аж ахуйд шилжиж, аж үйлдвэр-хөдөө аж ахуйд хоршооллосон хамтын сектор, жижиг хувийн өмчтөнг төрүүлсэн өмчийн олон хэлбэр бий болсон,

— Эдийн засгийн удирдлагын шинэ систем тогтож, социалист төлөвлөгөөт таваарын аж ахуйг зах зээлийн системтэй уялдуулан зохицуулсан,

— Эдийн засгийн талаар гадаадад нээлттэй байж, улс ардын аж ахуйг хөгжүүлэхэд гадаадын капиталыг өргөн ашиглах болсон,

— Шинэтгэлийн явцад жижиг таваар үйлдвэрлэгчид, хөлсний ажилчид буй болсон зэрэг шинэ нөхцөлүүд бүрэлдэв.

Эдгээр шинэ нөхцөл байдалтай уялдан нийгмийн хөгжлийн өнөөгийн шаардлагатай тохирохоо больсон улс төрийн системийн доголдолтой талуудыг өөрчлөх хэрэгцээ нэлээд эртнээс бий болсон билээ.

1980 оны 8-р сард хуралдсан ХКН-ын ТХ-ны Улс төрийн товчооны өргөтгөсөн хурал дээр Дэн Сяопины «Нам, төрийн удирдлагын журмыг өөрчлөх тухай хэлсэн уг нь БНХАУ-ын улс төрийн системийн шинэтгэлтэй холбогдсон программын шинжтэй анхдагч баримт бичиг² болсон юм. Уг баримт бичигт Хятадын социалист бүтээн байгуулалтанд дахь ХКН-ын удирдлагын урт удаан хугацааны түүхэн туршлага, «соёлын хувьсгал»-ын арван жилийн хор хөнөөлийг нэгтгэн дүгнэж, Хятадын улс төрийн системд буй үндсэн дутагдлыг нэг талаас аливаа хүнд суртал, удирдах байгууллагуудад эрх мэдэл хэт төвлөрөх, удир дах албан тушаалд насан туршаа байх зэрэг сөрөг хандлага газар авсантай, нөгөө талаас дундад зууны үеийн феодализмын нөлөө хүмүүсийн оюун санаанд хадгалагдсаар байгаатай холбон тайлбарлаж улс төрийн талаар жинхэнэ ардчилсан, бүрэн төгөлдөр хууль дүрэмтэй, хамгийн үр ашигтай улс төрийн системтэй болох шаардлага»-тайг онцолжээ.³

70-аад оны сүүлч 80-аад оны эхээр ХКН улс төрийн системд аливаа шинэчлэлт, өөрчлөлт хийхгүйгээр эдийн засгийн системийн шинэт-

гэлийг амжилттай хэрэгжүүлж чадахгүй гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Гэвч тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан эдийн засгийн системийн шинэтгэлийг улс төрийн системийн шинэтгэлтэй иж бүрнээр нь хослон явуулах нөхцөл бололцоо хараахан бүрдээгүй байлаа. Тухайлбал, улс төрийн системийн шинэтгэлээр хийх ажил тодорхой бус, хэрэгжүүлэх арга зам нь бүрхэг, эдийн засгийн хөгжлөөс урган гарсан олон шинэлэг нөхцөлийг танин мэдэж түүнд тохирохуйц ажлын арга барил бий болгоход бэрхшээлтэй, мөнхүү шинэтгэлийг гардан явуулах туршлага хангалтгүй, мэргэжил мэдлэгтэй боловсон хүчин дутагдалтай, улс төрийн амьдралд оролцох хөдөлмөрчин олон түмний идэвх нэн сул байв.

ХКН эдийн засгийн шинэтгэлийн эхний жилүүдэд онол, практикийн хувьд улс төрийн системийн шинэтгэл хийхэд зайлшгүй шаардлагатай бэлтгэл ажлын хүрээнд хувь хүнийг тахин шүтэх зуршлыг шүүмжлэх; нам, төрийн албан тушаалд насан туршаа сонгогддог буруу практикийг халах; нам, төрийн үйл ажиллагааг зааглах асуудлыг хууль эрхийн үндэстэй болгох; аж ахуйн талаар бие даахуйц үйлдвэрийн газруудад эрх мэдэл олгон, үйлдвэр аж ахуйн газрын удирдагчдын хариуцлагыг өндөржүүлэх; хууль тогтоомжийн үйл ажиллагааг идэвхжүүлэх; ардчиллыг гүнзгийрүүлэх ажлыг хийж байлаа.

Ялангуяа боловсон хүчний асуудлыг үлэмж чухалчлан 1982 онд хуралдсан ХКН-ын ХП их хурлаар бүрэн боловсролтой, мэргэжлийн Өндөр мэдлэгтэй боловсон хүчнийг улс төрийн чухал албан тушаалд томилж, халамжлан хүмүүжүүлэх зорилтыг анх дэвшүүлэн тавьсан юм. Сүүлийн жилүүдэд нэг сая орчим залуу, дунд насны боловсон хүчин удирдах албан тушаалд томилогдсоны дотор мужийн хэмжээнд мянга орчим хүн, районы хэмжээнд 20 мян, хүн. тойргийн хэмжээнд 140 мян, орчим хүн⁴ тус тус томилогдсон байна.

1984 оноос эхлэн Хятадын зарим үйлдвэрийн газрууд «үйлдвэрийн газрын дарга нарын хариуцлагын дүрэм»-д шилжиж орсон нь аж ахуйгаа бие даан хөтлөх эрхийг өргөтгөж, үйлдвэрийн газрын дарга нарыг бүтээлч, сэтгэн бодох ажиллагааг явуулах өргөн нөхцөлөөр хангажээ. 1986 оны байдлаар Хятадын 54 мян, үйлдвэрийн газрын 23 мянгад нь мөнхүү дүрмийг хэрэгжүүлж, улсын секторын 30 мян, гаруй үйлдвэрийн газрын дийлэнх нь үйлдвэрлэл явуулах эрхийн талаар бие даасан байна. Энэхүү «үйлдвэрийн газрын дарга нарын хариуцлагын дүрэм»-ийг улс төрийн талаас нь авч үзвэл нам, төрийн үйл ажиллагааг зааглах ажлын эхлэл хэмээн хэлж болно.

Дэн Сяопин 1986 оны 6-р сард намын ажлын арга барилыг цэгцлэх ажлын хуралдаан дээр «... өнөөгийн намын бүхий л ялзран доройтсон илрэл бүр нь бүгд улс төрийн системийн үр дагавар бөгөөд засгийн эрх барьж буй нам хязгааргүй эрх мэдэлтэй болсон явдал аливаа шудрага бус илрэлийн үндсэн шалтгаан мөн»⁵ гэж өгүүлсэн нь нэгдүгээрт, намын үйл ажиллагаанд шүүмжлэлттэй хандах шаардлагатайг; хоёрдугаарт, намыг төрийн үйл ажиллагаанаас зааглах асуудал хир тулгамдсан шинж чанартай болсоныг илтгэж байна.

Хятадын хүн амын дөрөвний нэг хувь нь бичиг үсэггүй, бичиг мэдэх хүн амын зонхилох хувь нь анхан шатны боловсролтой бөгөөд аливаа шинэтгэлд эрдэм мэдлэгтэй, соёл боловсролтой хүмүүс зүй ёсоор шаардлагатай. Хятадын нийгэмд байгаа үзэл санааны элдэв харш үзэгдэл, ёс суртахууны доголдлын учир шалтгааныг Хятад нь

феодалын нийгмийн 2000 жилийн түүхтэй улс орон бөгөөд иймээс ч улс төр ёс суртахууны талаар хүмүүсийн оюун санаанд үлдэж хоцорсон феодалын нийгмийн зуршлыг өнөө хир устгаж чадаагүйтэй холбон үзэж байна. ХКН-ын ТХ улс төрийн системийн шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлэх нэг гол үндэс нь хүмүүсийн оюун санаа, ухамсарт гүн гүнзгий өөрчлөлт хийх явдал хэмээн үзэж 1986 оны 9 дүгээр сард хуралдсан ХКН-ын ТХ-ны VI бүгд хурлаар «социалист оюуны соёлын байгуулалтын чиг шугамын тухай тогтоол» -ыг баталсан нь Хятадад улс төрийн системийн шинэтгэл явуулах бэлтгэл ажлын талаар авсан нэг томоохон арга хэмжээ болжээ.

1978 оны III бүгд хурлаас хойш эдүгээ хүртэлх хугацаанд ХКН улс төрийн системд шинэтгэл хийх бэлтгэлийг ийнхүү зугуухан хангасан, нөгөөтэйгүүр эрч хүчээ авсан эдийн засгийн системийн шинэтгэл хуучин улс төрийн системийн хоорондын зөрчил хурцдах болсонтой уялдан 1986 оноос эхлэн улс төрийн системд шинэтгэл хийх асуудал нэн хурцаар тавигдах болов. Тухайлбал Дэн Сяопин улс төрийн системийн шинэтгэл улам тулгамдсан шинжтэй болж буй талаар «.. өнөөгийн эдийн засгийн системийн шинэтгэлийн алхам бүр нь улс төрийн системийн шинэтгэл хийх зайлшгүй шаардлагатайг бид бүхэнд гүн гүнзгий ухамсарлуулж байна»⁶ гэж өгүүлжээ. ХКН-ын ТХ эдийн засгийн системд шинэтгэл хийсэн есөн жилийн хугацааны туршлага, шинэтгэлийн үр нөлөөгөөр бий болсон нийгэм-улс төрийн амьдралын шинэ нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэсний үндсэн дээр Хятадын улс төрийн системд шинэтгэл хийх төлөвлөгөөг нарийвчлан боловсруулжээ. 1987 оны X сард хуралдсан ХКН-ын XI их хурал улс төрийн системийн шинэтгэлийг иж бүрнээр нь намын бүхий л ажлын төлөвлөгөөнд дэвшүүлэн тавих бололцоо нэгэнт бүрдсэн хэмээн үзэж мөнхүү шинэтгэлийн хүрээнд хэрэгжүүлбэл зохих ажлыг дараахь чиглэлээр тодорхойлжээ.

**Нам, төрийн үйл ажиллагааг
зааглаж, анхан шатны нэгжид
эрх мэдэл олгох**

Хятадын коммунист нам, төрийн
байгууллагын үйл ажиллагаанд
тодорхой зааг хязгаар үгүйгээс

тэдгээрийн ажлын үүрэг, хуваарилалт хутгалдаж, нам нь төрийн засаг захиргааны ажлыг эн тэргүүнээ шүүрэн авч, үүрэгт ажлаа орхигдуулснаас намын удирдан чиглүүлэгч үүрэг роль буурч, төрийн байгууллагын ажлыг шууд гүйцэтгэгч болон хувирсан байна. Үүний улмаас төр, олон нийт, анхан шатны нэгж байгууллагын удирдагчдын эрх мэдэл хязгаарлагдаж, ажил хэргийг шийдвэрлэхэд бэрхшээл учирч, хүнд суртлын аливаа хэлбэр газар авч, төрийн байгууллагын ажилд тавих хяналт шалгалт суларсан зэрэг олон зүйлийн шийдвэрлэвэл зохих зөрчлүүд үүсчээ. Эдгээр зөрчлийг арилгах зорилгоор намын үйл ажиллагааг гадаад, дотоод бодлого, эдийн засгийн болоод улс орныг батлан хамгаалах асуудалтай холбогдсон улс төрийн зорилтыг дэвшүүлэх, төрийн эрх барих байгууллагын удирдах албан тушаалд нэр дэвшигсдийг тодорхойлох, аливаа ажил хэрэгт улс төрийн удирдлагыг баримтлах, олон нийтийн байгууллага, үйлдвэр аж ахуйн газрын үйл ажиллагааг зохицуулах явдал мөн хэмээн тодорхойлжээ.

Харин төрийн байгууллагууд нь хууль дүрэм, улс төрийн удирдамж заалт үйлдвэр, аж ахуйн газар хэрэгжиж буй эсэхэд хяналт тавих үүрэг хүлээсэн байна.

Засаг захиргаа, үйлдвэр аж ахуй, олон нийтийн байгууллага болоод зарим томоохон хотуудад бие даан шийдвэр гаргах эрх мэдэл олгож, намын байгууллагын зохион байгуулалтын хэлбэр, арга барилын асуудалтай холбогдуулан бүх шатны намын хороодын ажлын аппаратыг цомхотгох болов. 1987 оны XII сард Бээжин хотын намын хорооны бүгд хурал хуралдаж, Бээжин хотын намын хорооны нэгж байгууллагын 40% -ийг татан буулгах шийдвэр гаргасан⁷ нь мөнхүү ажлын эхлэл болов.

Засгийн газрын ажлын аппарат болон боловсон хүчний системийг өөрчлөх

Хятадын нийгэмд хүнд суртлын аливаа хэлбэр үүсч байгаагийн

учир шалтгаан нь засгийн газрын ажлын аппарат хэт нүсэр, шат дамжлага нь олон, үйл ажиллагаа нь тодорхой бус, эрх мэдлээ булаалддаг оршиж байна.

Хятадын нам, төрийн удирдлага засгийн газрын байгууллагуудын аппаратыг өөрчлөхдөө орон тоог цомхотгох, байгууллагуудыг нэгтгэх, үр ашигтай байх зарчмыг баримтлах үндсэн ажилтнуудыг зөвөөр хуваарилах явдал зайлшгүй шаардлагатайг онцолж, аппаратын өөрчлөлтийн үр дүнг батжуулах зорилгоор засаг захиргааны удирдлагыг хуульчилж, орон тооны хуулийг тогтоон, санхүүгийн аргыг ашиглан ажилтнуудын орон тоонд хяналт тавьж, өөрсдийн албан үүргийг биелүүлээгүй, эрх мэдлээ хортойгоор ашиглаж намын сахилга бат зөрчигсдийг хариуцлагад татах хуульчилсан арга хэмжээ авахаар тогтжээ.

Удирдлагын эрх мэдэл хэт төвлөрсөн, удирдах ажилтнууд удирдлагын ажлаас хөндийрсөн, арга барил нь хуучирсан, авьяаслаг залуу боловсон хүчнийг өсөн дэвжихэд саад хийдэг боловсон хүчний хуучин системийг халж улсын албан хаагчдын шинэ системийг буй болгон, хуульд түшиглэсэн шинжлэх ухааны удирдлагаар хангах болов. Улсын албан хаагчид бэлтгэх ажилтай холбогдуулан төрийн засаг захиргааны дээд сургууль байгуулах асуудал ч мөн хөндөгдөж байна.

Нийгмийн зөвлөлдөн хэлэлцэх системийг буй болгож, социалист ардчилсан улс төрийн зарим байгууллагыг төгөлдөржүүлэх
«нийгмийн зөвлөлдөн хэлэлцэх»

ХКН аливаа асуудлыг зөвлөн хэлэлцэж, олон түмний санаа бодлыг үнэн зөв тусгах системтэй болохыг зорьж байна.

ХКН-ын XIII их хурлаар баталсан нийгмийн зөвлөлдөн хэлэлцэх системийн асуудлаар олон нийтийн дунд санал хураалтын ажлыг 1987 оны XI сард зохион байгуулж, түүнд оролцогчдын 87,6% нь мөн системийг шаардлагатай зүйл гэж дэмжсэнээс үзэхэд Хятадын олон нийт уг системийг нэлээд нааштайгаар хүлээн авсан байна.

БХАТИХ, Байнгын хорооны олон талт үйл ажиллагааг цаашид боловсронгуй болгож ардчилсан намын бүлгүүд, Улс Төрийн Зөвлөл-

дөх Зөвлөлийн улс төрийн амьдралд гүйцэтгэх үүрэг ролийг хөгжүүлэх, үйлдвэрчний эвлэл, залуучуудын байгууллага, эмэгтэйчүүдийн холбоо зэрэг олон нийтийн байгууллагын ажлыг цаашид бэхжүүлэх, сонгуулийн системийг улам бүр ардчилах асуудлыг социалист ардчилсан зарим байгууллагыг төгөлдөржүүлэх ажлын хүрээнд хэрэгжүүлэхээр тогтжээ.

Социалист хууль дүрмийг бэхжүүлэх

БНХАУ-д эдийн засгийн шинэтгэлийг өрнүүлж, улс төрийн системийн шинэтгэлийг эхэлж буй тухайн нөхцөлд тэдгээрийн хөгжлийн онцлогт тохирсон хууль дүрмийн шинэ систем буй болгох явдал үлэмж тулгамдсан шинжтэй асуудал болон тавигдаж байна. ХКН-ын XIII их хурлаас шинэ маягийн социалист хууль дүрмийг бий болгох, иргэдийн хуулийн мэдлэгийг нэмэгдүүлэх, нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан нарийн чанад хууль дүрмийг боловсруулах⁸ зорилт тавив.

Ийнхүү ХКН-ын XIII их хурлаас олон жилийн турш яригдан, хэлэлцэгдэж байсан улс төрийн системийн шинэтгэлийг тус оронд хэрэгжүүлэхээр тогтсон нь Хятадын нийгэм улс төрийн амьдралд гарсан нэгэн томоохон чухал үйл явдал боллоо.

ХКН улс төрийн системийн шинэтгэлийг тус оронд хэрэгжүүлснээр эдийн засгийн системийн шинэтгэлийг эрчимжүүлэх; нам, төрийн үйл ажиллагааг зааглах; засгийн газрын ажлын аппаратыг цэгцэлж, боловсон хүчнийг бэлтгэх, шилж сонгох, хуваарилах системийг өөрчлөх; ардчилалыг хөгжүүлэх хэд хэдэн үндсэн зорилтыг шийдвэрлэх юм.

Эдгээр нь урт удаан хугацааны туршид үргэлжлэх хүнд бэрх, ээдрээтэй зорилт болох нь зүйн хэрэг бөгөөд БНХАУ-д хэрэгжүүлж эхэлсэн улс төрийн системийн шинэтгэлийн үр дүн нь түүний цаашдын хөгжлөөр улам бүр тодорхойлогдох болно.

¹ **Дэн Сяопин** «Основные вопросы современного Китая» Пекин, 1987, с. 117

² Ляован 1987, N 27, 9-р тал

³ **Дэн Сяопин** «Вэнь Сюань (1975—1982) », Бэйцзин, 1983, 280-р тал

⁴ Beijing Review 1987, No 38, p. 6—7

⁵ Чжунгун яньцзю 1986, No 8, 1—4-р тал

⁶ Ляован 1987, No 27, 9-р тал

⁷ Та кунг рао 1987, 12. 17

⁸ Документы XIII всекитайского съезда Коммунистической Партии Китая. Пекин, 1987, с. 45—65